

2019 оны Хувь Нийлүүлэгчдийн хурлын тэмдэглэл

Хувь нийлүүлэгчдийн ээлжит хурлыг 2020 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 09:00 цагт компанийн өөрийн байранд эхлүүлэв.

Оролцсон:

Н.Соёмбо- Компанийн 35544 ширхэг хувьцаа эзэмшигч

М.Алтанцэцэг- Гүйцэтгэх захирал

Э.Норовренчин- ТУЗ-ын гишүүн

Н.Тулга- ТУЗ-ын гишүүн

Х.Анар- ТУЗ-ын гишүүн

Н.Хишигсүрэн- ТУЗ-ын гишүүн

А.Ганцэцэг- Нягтлан бодогч

Ж.Нямдэлгэр- ТУЗ-ын гишүүн

Г.Даваажаргал - Компанийн ажилтан

А.Сэлэнгэ-Компанийн ажилтан

Хурлын ирц 67,62 хувь байгааг Хувь нийлүүлэгчдийн хурал зохион байгуулах комиссын дарга Х.Анар танилцуулж хувь нийлүүлэгчдийн хурлыг эхлүүлэх саналыг тавилаа.

“Монгео” ХК-ийн 2019 оны ээлжит Хувь нийлүүлэгчдийн хурлын даргад Н.Соёмбо өөрийн нэрийг, хурлын нарийн бичгийн даргад Э.Норовренчиний нэрийг дэвшүүлж, хуралд оролцогсдын 100 хувийн саналаар хурлын дарга, хурлын нарийн бичгийн дарга нарыг сонголоо.

Хэлэлцсэн нь:

- Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн жилийн эцсийн тайлангийн талаар ТУЗ-ийн хурлын шийдвэрийг хэлэлцэх, батлах
- Аудиторын дүгнэлт
- Компанийн үндсэн үйл ажиллагаатай холбоотойгоор Улсын болон орон нутгийн чанартай зохион байгуулагдах ажилд компанийн хөрөнгө санхүүгийн чадавхийг харгалзан идэвхитэй оролцох, түүнд шаардлагатай төсөв төлөвлөгөөг тухай бүрт нь ТУЗ-ийн хурлын шийдвэрээр баталж шийдвэр гаргах,

- Харьяа байгууллагуудаас гаргасан тогтоол шийдвэр, удирдамж, холбогдох хууль тогтоомж, компанийн дүрмээр тогтоосон асуудлын хүрээнд компанийн бусад асуудлыг хэлэлцэж шийдвэрлэх,
- Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах,
- Компанийн үйл ажиллагааг өргөжүүлэх, санхүүгийн тогтвортой байдлыг хангах, цаашид бизнес эрхлэгтэйгээр холбоотойгоор их хэмжээний зээл авах, гэрээ хэлцэл байгуулахыг гүйцэтгэх захиралд зөвшөөрөх,
- Компанийн эзэмшлийн ХУД-ийн 12-р хорооны нутаг дэвсгэрт байрлалтай 10,7 га ногоо, тариалах зориулалтын газрыг тус компанийн хуримтлагдсан санхүү, татварын өрийг тэглэх, үйл ажиллагааны тогтвортой байлыг хангах зорилгоор удаан хугацаагаар түрээслэх, үндсэн хөрөнгөөс хасах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх,

Хурлын явц:

“Монгео” ХК-ний 2019 оны үйл ажиллагааны тайланг гүйцэтгэх захирал М.Алтанцэцэг танилцууллаа.

Өнгөрсөн оны Хувь нийлүүлэгчдийн хурлын болон ТУЗ-ийн хурлын шийдвэрүүд, холбогдох дээд байгууллагаас өгсөн тушаал шийдвэр журам, албан шаардлага зэргийг мөрдлөгө болгон компанийн үйл ажиллагааг удирдан гүйцэтгэлээ. Өнгөрч буй онд түрээслэгч аж ахуй нэгж цөөн байсан учир орлого өмнөх оноос нэмэгдээгүй. Өдөр тутмын ажил хэвийн үргэлжилж байлаа. Компани ҮЦТХТөв ХХК-тай Үнэт цаасны хадгаламжийн гэрээг хуульд заасан хугацаанд байгуулж, гэрээний үүргээ биелүүлж ажиллалаа. “Монгео” ХК 2019 онд 8 хүний бүрэлдэхүүнтэй ажилласан. Сар бүрийн 20-25-ны өдрүүдэд төвлөрдөг түрээсийн орлогоос цахилгаан, дулаан, ус, НДШ-ийн төлбөрт зохицуулан хуваарилж байгаа хэдий ч, нийт зардалд хүрдэггүй болно. Иймээс НӨАТ, ХХОАТ-ын үлдэгдэл өр үлдэж сар бүр хуримтлагдаж байна. Ногдол ашиг хуваарилах боломж бүр ч байдаггүй юм. Төлбөл зохих төлбөрийг боломжоороо төлж байсан боловч оны эцэст НӨАТ-д 6287296.60 төгрөгийн, ХХОАТ-д 3020999.98 төгрөгийн, НДШ-д 781000 төгрөгийн өглөгтэй тайлагнасан байна. НДШ-ийг бид 2020 оны 1-р улиралд багтаан төлж дуусгана. Цаашид хоосон байгаа өрөөнүүдийг түрээслэх, үйл ажиллагаандаа хүн бүр анхааран ажиллана.

А.Ганцэцэг: “Монгео” ХК 2019 оны санхүүгийн үйл ажиллагааны тайланг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн зарчмын дагуу, бусад хууль тогтоомж, дүрэм журмыг үндэслэн үнэн зөв тайлагнасан болно. 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Би энд Си Аудит ХХК-аар баталгаажуулсан ба зөрчилгүй дүгнэлт гарсан болно. Санхүүгийн тайлан балансаас харахад мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө нь 2019 оны жилийн эцсийн байдлаар 636341 төгрөгийн үлдэгдэлтэй, ААНОАТ авлага нь 950500 төгрөг, Хөрөнгө оруулалтын зориулалттай хөрөнгийн дүнд өөрчлөлт гараагүй, Дулааны шугам сүлжээ ТӨК-д 263300

төгрөг, СХД-ийн татварын хэлтэсд НӨАТ-д 6287296.60 , ХХОАТ-д 3021000 төгрөг, НДХэлтэсд 781000 төгрөгийн өглөгтэй байгаа юм. Энэ нь Санхүүгийн хувьд бие даасан боловч эргэлтийн хөрөнгийн чадвар маш сул байгааг харуулж байна.

Аудиторын дүгнэлт:

2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Б энд С аудит ХХК аудитын компаниар хийлгүүлсэн ба санхүү байдлын тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, орлогын стандартын дагуу үнэн зөв хийгдсэн байгааг дүгнэж, зөрчилгүй дүгнэлт өгсөн болно гэж танилцуулав.

Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай Х.Анар танилцууллаа.

1. Компанийн хаяг, утасны дугаар өөрчлөгдсөн.
2. Эрхлэх үйл ажиллагааны чиглэлд нэмэлт хийх “Эмнэлэг, сувиллын үйл ажиллагаа”
3. Мөнгөний ханшийн уналт, мөнгөний доллартай харьцах харьцаа тасралтгүй нэмэгдэж байгаа байдал зэргийг харгалзан Гүйцэтгэх захиралд зөвшөөрсөн зээлийн хэмжээг нэмэгдүүлэх хэрэгтэй гэж үзэж энэ талаар компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай байна гэв.

Санал шүүмжлэл:

Н.Соёмбо: Үйл ажиллагааны болон жилийн санхүүгийн тайлангуудтай танилцлаа. Өмнө оноос өөрчлөгдсөн зүйл харагдсангүй. Татваруудаас НДШ-ийг харьцангуй төлөөд явдаг, юм байна.

Гэхдээ сул байгаа өрөөнүүдийг түрээслэх ажлыг далайцтай хийх хэрэгтэй. АМХЭГ-аас зарлагдах тендерт оролцож болох юм. Гэхдээ геологийн судалгааг нарийн хийсэн ашигт малтмалын тогтоц насжилт гэх мэт нарийн юмсыг нь их сайн тооцсон газрыг сонирхмоор юм билээ. Хэрэв судалгаанд түшиглэн оролцох болбол зохих шийдвэрийг гаргаж, санхүүгийн боломж бололцоог гаргана гэж л зүтгэнэ. Дүрмийн өөрчлөлтөд санал хэлэхэд гүйцэтгэх захирлын мэдэлд шийдвэрлэх, зээлийн хэмжээг 350000000 сая биш 150000000 сая гэж авбал зүгээр байх.

Н.Хишигсүрэн: Тайлангуудыг сонсож мэдлээ. Түрээслэх ажиллагаагаа сайн явуулъя. Компани өөрөө орлого олж болох боломжийг судлах хэрэгтэй гэж санагдлаа. Жижигхэн үйлдвэрлэл явуулах ч юм уу, өдөр тутам орлоготой байх зүйл зохион байгуулж чадвал нэмэртэй дээ.

Хурлаас гарах шийдвэрийг дэмжиж хүлээн авна. Дүрмийн нэмэлт өөрчлөлтийг дэмжиж байна.

Э.Норовренчин: Компанийн 2019 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлантай танилцлаа. Гол нь компани өөрийн мэргэшсэн үйл ажиллагаатай байх нь чухал. Үүний тулд сайн анхаарч үндсэн чиглэлээсээ барьж авах нь зүйтэй. Энэ тал дээр судалгаатай анхаарсан байдлаар ажиллавал зүгээр байх. Хурлаас гарах шийдвэрүүдийг хүлээн авна аа.

Н.Тулга : Жилийн эцсийн бүх тайлан мэдээллийг сонсож танилцлаа. Компани оршин тогтнохын тулд ахицтай дорвитой ажил зохион байгуулж санхүүгийн чадамжаа сайжруулах хэрэгтэй. Үүний тулд үйл ажиллагааны чиглэлээ заавал геологийн хайгуул, зураглал гээд суугаад байх биш . Бусад чиглэлийг ч судлах шаардлагатай. Тухайлбал улс орны эдийн засгийн байдалтай уялдуулж дүрмэндээ заагдсан иргэний болон үйлдвэрлэлийн барилга угсралтын зураг төсөл боловсруулах , угсралт хийх чиглэлээ барьж авсан ч буруудах зүйлгүй. Бүгдээрээ хэлэлцэж цаашид хийх зүйлээ тооцоолж ажиллъя. Тэгж байж компани санхүүгийн чадамжтай болж орлого нь ч өснө байх. Дүрэмд оруулж буй нэмэлт өөрчлөлтийг дэмжиж байна.

А.Ганцэцэг : Манай компани хувьцаагаа олон нийтэд нээлттэй зарлаж , нэмж хувьцаа гаргах замаар хөрөнгө босгох ажилд ээр анхаарч судалж санхүүгийн бие даасан чадавхийг сайжруулж болох үндсэн үйл ажиллагаандаа тулгуурласан төсөл хөтөлбөр болон бусад ажлуудыг боловсруулах замаар илүү өргөн цар хүрээтэйгээр явуулах нөхцлийг бүрдүүлэх тал дээр анхаарч ажиллавал зүгээр байх гэж бодож байна. Иймээс энэ ажил дээр анхаарч ажиллах саналыг гаргаж байна. Мөн компанийн дүрмэнд орсон нэмэлт өөрчлөлтийг дэмжиж байна .

Х.Анар : 2019 оны санхүүгийн жилийн эцсийн тайлан болон үйл ажиллагааны тайлантай танилцлаа. Мөн компанийн хувьд 2019 онд эдийн засгийн нөхцөл байдлаас үүдэн үндсэн үйл ажиллагааны чиглэлээрээ дорвитой ажлыг хийж чадахгүй өдийг хүрсэн.

АМХЭГ-аас зарлагдсан сонгон шалгаруулалтад тогтмол оролцсоор ирсэн гэвч тодорхой зарласан газруудад мэргэжлийн судалгаа шинжилгээг үе шаттайгаар хийж үзэхэд цаашид урт хугацаанд үр өгөөж өгөх газар төдийлөн гарахгүй хойшлогдсоор өдийг хүрлээ.

Компанийн барилгыг оффис болон үйлдвэрлэлийн зориулалтаар түрээслэж дүүргэлтийг тодорхой хувиар өсгөж байгаа хэдий ч төдийлөн зардлаасаа илүү гарч чадахгүй байгаа. Иймд үйл ажиллагааны чиглэлээ өргөжүүлж тооцоо судалгааг сайн хийж төсөл хөтөлбөрүүдийг боловсруулж байгууллагын хувьд санхүүгийн чадавхийг дээшлүүлж сайжруулж ажиллах нь бидний хувьд нэн тэргүүний ажил болоод байна. Дүрмэнд оруулж буй нэмэлт өөрчлөлтийг хүлээн зөвшөөр ч байна.

Ж.Жаргалсайхан : Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан , аудиторын дүгнэлттэй танилцлаа.

Ер нь компанийн үйл ажиллагааг дүрэмд заагдсан өөрийн чиглэлээр нь ажиллуулах саналтай байна.

Барилгын болон геодези, кадастрын зураглал хийх чиглэл рүү оруулж болох юм.

Мэргэжилтэй боловсон хүчнийг сайн судалж авах хэрэгтэй. Зохих журмын дагуу үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлөө холбогдох байгууллагаас нь авах байх. Тооцоогоо сайн хийж тодорхой хэмжээний зээл авах, бусад зүйлийг хийж гүйцэтгэхэд анхаарч ажиллавал яасан ю бэ? Сайн бодолцож зөвшилцөж шийдвэр гаргаж ажиллах нь зүгээр гэж бодож байна. Дүрмийн өөрчлөлтийг дэмжиж байна.

М.Алтанцэцэг : Хуралд оролцож буй хүмүүсийн ярьсан, хэлсэн санаа оноог сайн ойлголоо. Ажил хэрэг болгох тал дээр анхаарч ажиллана гэж бодож байна. Санхүүгийн чадамж дээшилбэл бүх тал дээр ахиц гарна. Гадна, дотны түнштэй болж хамтран ажиллах ч болно байх. Компанийн дүрмийн өөрчлөлтийг дэмжиж байна гэснээр санал шүүмжлэлийг тасаллаа.

Шийдвэрлэсэн нь :

Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн жилийн эцсийн тайланг зөвшөөрөхөөр,

Аудиторын дүгнэлтийг зөвшөөрөхөөр,

ТУЗ-ийн хурлын шийдвэрийг үндэслэн компанийн үндсэн үйл ажиллагаатай холбоотойгоор улсын болон орон нутгийн чанартай зохион байгуулагдах ажилд мэргэжлийн ур чадвар сайтай баг бүрдүүлэн ороцохыг гүйцэтгэх удирдлагад үүрэг болгохоор,

Компанийн дүрмийн нэмэлт өөрчлөлтийг батлахаар,

Компанийн үйл ажиллагааг өргөжүүлэх санхүүгийн тогтвортой байдлыг хангах, цаашид бизнес эрхлэхтэй холбоотойгоор их хэмжээний зээл авах, гэрээ хэлцэл байгуулахыг гүйцэтгэх захиралд зөвшөөрөхөөр,

Компанийн эзэмшлийн ХУД-ийн 12-р хороонд байрлалтай 10,7 га газрыг ногоо тариалах зориулалтаар 5-10 жилийн хугацаатайгаар түрээслэхийг зөвшөөрөхөөр тус тус шийдвэрлэлээ.

Хурлыг 2020 оны 04 сарын 29-ны өдрийн 12 цаг 25 минутанд дуусгав.

Тэмдэглэл хөтөлсөн /Н.Тулга /

